



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 1129

Шивээговь сум

Монголын ард түмний спортын XV  
наадамд бэлтгэж оролцуулах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний наадам зохион байгуулах тухай журам”-ын 2.1 дэх заалт, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын газрын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн A/17 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн A/62 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монголын бүх ард түмний спортын XV их наадмын анхан шатны тэмцээнийг зохион байгуулах, шигшээ тэмцээнд бэлтгэн оролцуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Сувд-Эрдэнэ

(1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Батгантиг

(Шивээ-Овоо хувьцаат компанийн  
Ээлжийн дарга)

Г.Наранбат

(Ерөнхий боловсролын сургуулийн  
Биеийн тамирын багш)

Г.Наранбаатар

(Соёлын төвийн техникч)

Л.Цэрэн-Очир

(Шагайн холбооны тэргүүн)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2. Монголын бүх ард түмний спортын XV их наадмын анхан шатны тэмцээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, өндөр түвшинд зохион байгуулан, шигшээ тэмцээнд амжилттай бэлтгэн оролцуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан, үр дүнг тайлагнахыг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНЧИМЭГ

